БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДНА ТОГЛООМЫН ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖЛЫН СТАНДАРТ, АЖЛЫН ТӨСӨВ

2026 он

БАЯН-ОВОО СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баян-Овоо сумын цэцэрлэг нь 1961 оны 10 дугаар сарын 15-нд Мал аж ахуйн машинист станц МААМС-ыг түшиглэн 25 ортой 3 орон тоотойгоор байгуулагдсан түүхтэй. 2021 онд 150 хүүхдийн стандартын 1 тэрбум 500 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад орж бага насны хүүхдийн сурч хөгжих, ажиллах орчин бүрдсэнээр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт нэмэгдэж 4 бүлэгтэй, 20 багш ажилчидтайгаар өргөжин ажиллаж байна.

БИДНИЙ ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛ

- Маш сайн тоглож сурсан хүүхэд
- Эрүүл хүүхэд
- Бүтээлч хүүхэд

Маш сайн тоглож сурсан хүүхэд

- Монгол ардын тоглоомын төрөл шагай, хөлөгт, оньс, ээдрээ тайлах, уяа зангилаа, үгэн тоглоом зэргээс суралцаж маш сайн тоглож сурах
- Бусадтай хамтран тоглох
- Өөрийн сонирхсон тоглоомоор тоглох
- Тоглонгоо өдөр тутмын амьдрах ухаанд суралцах

Эрүүл хүүхэд

- Хүүхэд цэцэрлэгтээ ирэхдээ баяр баясгалантай ирж орой сэтгэл дүүрэн харих
- Зөв хэвшил дадал эзэмших
- Өөртөө үйлчилж сурах
- Зөв зохистой хооллох

Бүтээлч хүүхэд

- Өөрийнхөө хийж чаддаг зүйлээс өөрөө хийх, шаардлагатай үед бусдаас тусламж хүсэх
- Тоглонгоо өдөр тутмын амьдрах ухаанд суралцаж найзтай болох
- Аливаа зүйлд сэтгэлийн хөдөлгөөнтэй хандаж ,янз бүрийн аргаар бодол сэтгэлээ илэрхийлэх
- Хүүхэд сурах гэсэн тэмүүлэлтэй байх
- Хийж буй зүйлээ эцэсийг нь хүртэл хийж дуусаны дараагаар эмхэлж цэгцлэх
- Шинэ зүйл болгонд дур сонирхолтой хандах

ЦЭЦЭРЛЭГИЙН ОНЦЛОГ

- Багшлах боловсон хүчний хувьд мэргэжлийн багшаар 100% хангагдсан
- Хүүхэд хөгжүүлэх сургалтын таатай орчинг бүрдүүлж чадсан.
- Эцэг эхийн хамтын ажиллагаа төлөвшсөн.
- Бага насны хүүхдийг хөгжүүлэх арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж ажиллаж байна.

БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хаяг: Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, Мэргэн 4-р баг

Утас: 976-(91114341, 88442122, 88757304)

1.1 Төслийн зорилго:

- ✓ Цэцэрлэгийн эзэмшил газарт хүүхдийн онцлог, хэрэгцээ, сонирхолд нийцсэн хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомын талбай байгуулах

1.2 Төслийн зорилтууд:

- ✓ Хүүхдүүд аюулгүй орчинд тоглох
- ✓ Цэцэрлэгт хүүхдэд ээлтэй орчныг бий болгохын тулд стандартад нийцүүлэн тохилог орчин бүрдүүлэх.
- ✓ Хөдөлгөөнийг дэмжсэн стандартад нийцсэн орчин бүрдүүлэх

1.3 Төслийн хэрэгцээ:

Баян-Овоо сум нь цэцэрлэгийн насны 167 хүүхэдтэй бөгөөд үндсэн болон хувилбарт сугалтаар дамжуулан 100 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж байна. Манай цэцэрлэг нь 4 бүлэгт 100 гаруй хүүхдийг хамруулдаг ба хүүхдүүдийн гадна тайлбайд стандартын дагуу тоглоом дутагдалтай тул хүүхдийг гадна талбайн тоглоом дээр тоглуулах боломж нөхцөл бүрдэхгүй байна. Иймд стандартын дагуу хүүхдийн насны онцлогт тохирсон хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомтой болох зорилготой.

1.4 Төсвийн санхүүжилт: Орон нутгийн хөгжлийн сан 50.000.000 төгрөг

Төслийн санхүүжилтыг гэрээ байгуулахад 30 хувь, ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн тохиолдолд дараагийн 30 хувийг, ажил гүйцэтгэж дууссаны дараа 40 хувийг олгоно.

1.5 Төслийн үр дүн

Эрүүл, аюулгүй орчинд хүүхдийн хөгжлийг дэмжин бага насны хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлж багш нарын арга зүйд ахиц гарна.

1.6 Гадна тоглоомын талбайд тавигдах стандарт шаардлага

Цэцэрлэгийн эзэмшил газарт тоглоомын талбай байхаас гадна хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийг хангах, дасгал хөдөлгөөн хийх, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулахад зориулагдсан биеийн тамирын талбайг байгуулна. Биеийн тамирын талбайг хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд ногдох талбай 1м2 ба нэг талбайн хэмжээ 150м2 -250м2 байхаар төлөвлөнө. Биеийн тамирын талбайн тоног төхөөрөмжийг тогтмол засан сэлбэж, талбайд хүүхэд бэртэж гэмтэхээс сэргийлэн зүлэг, элс, зөөлөвчин шалавч зэргийг хийж өгнө. Биеийн тамирын талбайд хүүхдийн нас, биеийн онцлогийг харгалзсан, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомын хэрэгслийг байрлуулахаас гадна спорт тоглоомын орчин бүрдүүлж өгөх хэрэгтэй. Тоглоомын талбай дахь бүх хэрэгслүүдийн хоорондох зай 2-6 метр зайтай байна.

MNS 6558: 2015 Шаардлага 5.1.3 Тоглоомын болон биеийн тамирын талбайд хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхолд нийцсэн, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоом байрлуулах ба тоглоом нь ISO 8124 цуврал стандартын шаардлага хангасан байна. Холбогдох эрх зүйн баримт бичиг: MNS ISO 8124-4:2011 Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг (Гадна ба дотор ашигладаг савлуур болон гулсуур түүнтэй адил тоглоомууд)

Цэцэрлэгийн эзэмшил газарт хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, сонирхолд нийцсэн, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомуудыг байрлуулна. Мөн тухайн цэцэрлэгийн өөрийн онцлог, зуны, нүүдлийн цэцэрлэг ажиллуулах зэрэг үйл ажиллагаанаас хамаарч зөөврийн тоглоом ашиглаж болно. Тоглоомын талбайн тоглоом, тоног төхөөрөмжид дараах нийтлэг шаардлага тавина. Үүнд: Тоглоом, тоног төхөөрөмж тус бүрийн эрүүл, аюулгүй байдлыг хангах; Зөөврийн тоглоом, биеийн тамирын тоног төхөөрөмжийг ашиглахдаа хүүхдийн бие махбодод гэмтэл учруулахгүй байхаар тогтвортой байршуулах; Гулсуур, авирах шат, дүүжин, савлуур зэрэг тоглоомоор тоглох, дугуй унах, цас мөсөн дээр гулгах үеийн аюулгүй байдлыг хангах; Тоглоомын талбайд элс, зөөлөвчин шал, зүлэг, угаасан хайрга зэрэг зөөлөн гадаргуутай хамгаалалт хийж хүүхдийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах; Тоглоом, биеийн тамирын талбайн тохижилт, тоноглолын их засвар хийх жишиг хугацаа 4 жил байна.

Суурин тоглоом.

Тоглоомын талбайд сүүдрэвч, гулсуур, дүүжин, элсээр тоглох талбай, савлуур зэрэг суурин тоглоом байх ба тухайн тоглоом хэд байх, тоглоомын талбайн аль хэсэгт байрлуулахыг цэцэрлэгийн эзэмшил талбайн хэмжээ, боломж нөхцөл, хүүхдийн тоог харгалзан байгуулна. Суурин тоглоомыг хөдөлгөөнгүй суурилуулж, суурь хэсэгт нь зөөлөн шалавч байрлуулах хэрэгтэй. Тоглоомын гадаргуу нь хурц ирмэг, ил цухуйсан эрэг шураггүй байх нь эрүүл, аюулгүй байдлыг хангана. Эдгээр суурин тоглоомын зарим эд ангийн хэмжээг MNS6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны ерөнхий шаардлага стандартын хавсралтаас харж танилцаарай.

Тоглоомыг суурилуулах заавар, угсрах арга нь шошго эсвэл түүнийг дагалдах бичигт тусгагдсан байдаг тул заавал танилцах шаардлагатай. Савлуур болон хөдөлгөөнт, суурин тоглоомыг угсарч, суурилуулахдаа дараах зааврыг баримтална. Савлуур, хөдөлгөөнт тоглоомыг ямар нэгэн байгууламжаас дор хаяж 1, 8 м зайд байрлуулах эсвэл хашаа, гараж, байшин, хэц, унжсан салаа мөчир, угаалгын газрын шугам хоолой, цахилгааны утас зэрэгт саад учруулахгүй газар суурилуулах;

Энгийн хэрэглээний үед болон санаандгүй тохиолдлоор буруу хэрэглэх явцад тулгуурын бусад элементүүд өргөгдөх, бэхэлгээний хэрэгсэл мултарч хөмрөхөөс сэргийлэхийн тулд зангуу, гадас зэрэг бэхэлгээг суурилуулах, хөрсний бүтцийг онцгой анхаарах; Бүдрэх, тээглэх аюулыг багасгахын тулд зангуу, гадсыг газартай тэгшлэх эсвэл газарт гүн суулгаж өгөх; Дүүжин даажин, савлуур, гулсуур, авирах шат зэрэг хөдөлгөөнт тоглоомуудын зааварт элс, хөөс, хаймар, модны холтос, үртэс зэрэг нь суурилуулахад хэрхэн нөлөөлөх талаар тусгагдсан байгаатай урьдчилан заавал танилцах; |Савлуурын дүүжлэх хэсэг нь бөх бат, уян материалаар хийгдсэн, хүүхэд барихад тохиромжтой байх; Савлуурт хүүхэд тоглож байх үед бусад хүүхэд урдуур, хойгуур нь явахдаа болгоомжтой байхыг сануулах; Тоглоомыг битум, цемент зэрэг аливаа хатуу гадаргууд суурилуулж болохгүй.

Сүүдрэвч MNS 6558: 2015 Шаардлага 5.1.6 Тоглоомын талбайд хүүхдийн тооноос хамааран сүүдрэвчтэй байна. Холбогдох эрх зүйн баримт бичиг: БНбД II-66-88 Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм ЗӨВЛӨМЖ Нарны хэт туяа, салхи, агаарын элдэв тунадсаас хүүхдийг хамгаалах, амрах, тоглоход зориулан бүлгийн хүүхэд байрлах хэсэгт 40м2 талбайтай сүүдрэвч төлөвлөж өгнө. Сүүдрэвч барих талбайн хэсгийг зөв сонгох нь чухал. Мөнх цэвдэг хөрстэй нутаг дэвсгэрт барих сүүдрэвч нь модон шалтай байх ёстой. Сүүдрэвчийг барихдаа өөрийн цэцэрлэгийн онцлог, хүчин

чадал, хүүхдийн сонирхолд нийцүүлэн хэд хэдэн төрөл, хэлбэрээр байгуулах бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Сүүдрэвчийн шалыг газраас 15см-ээс багагүй өндөрт байлгана.

Сүүдрэвчийн талуудыг 1.5м-ээс доошгүй өндөртэй хашлагаар тусгаарлана. | Сүүдрэвчийн сандлын хэмжээ нь хүүхдийн наснаас хамааран 18-34см өндөртэй байна.

Сүүдрэвчийг хийх материалд хорт бодис ялгаруулах хуванцар, шилэн хийц ашиглахыг хориглоно.

Элсний талбай Элсээр тоглох нь хүүхдийн танин мэдэхүй, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, туршилт хийх, найз нартайгаа хамтарч тоглоход ач холбогдолтой. Элсний талбайд хүүхдийн хөгжлийн онцлог, хөдөлгөөний чиглэлд тохируулан, ус авах цорго байрлуулж ус зөөх, усаар тоглох хэсгийг хамтад нь шийдвэл илүү сонирхолтой болно.

Элсний хайрцагны хашлагыг 20-30см өндөртэй, хүүхдэд аюулгүй материалаар хийнэ. Мөн элсний хайрцагыг талбайн хэмжээнээс хамаарч сүүдрэвчний хамт давхар шийдэлтэй хийж болно.

Элсийг сонгохдоо дараах хэмжээсийг харгалзан сонгохыг зөвлөж байна. Элс нь бүдүүн (1-2мм), том (1-0, 5мм), дунд (0.5-25мм), жижиг (0.25-0.1м), нарийн (0.1-0.05мм) ширхэгтэй байх ба цэцэрлэгт дундаас бүдүүн ширхэгтэй элсийг сонгож хэрэглэнэ. Нарийн буюу жижиг ширхэгтэй элс нь хүүхдийн нүд, чих, хамар, аманд орж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхаарвал зохино. Элсийг гадны бохирдолоос хамгаалж бүтээнэ.

Цэцэрлэгийн эзэмшил газарт тоглоомын талбай байхаас гадна хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийг хангах, дасгал хөдөлгөөн хийх, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулахад зориулагдсан биеийн тамирын талбайг байгуулна. Биеийн тамирын талбайг хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд ногдох талбай 1м2 ба нэг талбайн хэмжээ 150м2 -250м2 байхаар төлөвлөнө. Биеийн тамирын талбайн тоног төхөөрөмжийг тогтмол засан сэлбэж, талбайд хүүхэд бэртэж гэмтэхээс сэргийлэн зүлэг, элс, зөөлөвчин шалавч зэргийг хийж өгнө. Биеийн тамирын талбайд хүүхдийн нас, биеийн онцлогийг харгалзсан, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомын хэрэгслийг байрлуулахаас гадна спорт тоглоомын орчин бүрдүүлж өгөх хэрэгтэй. Тоглоомын талбай дахь бүх хэрэгслүүдийн хоорондох зай 2-6 метр зайтай байна. Үүнд: | Уртын харайлтын замын өргөн 1, 5-2м, урт 8-10м, замын төгсгөлд газардахад зориулж 3м урт, 1, 5-2м өргөн, 30х40см гүнтэй нүх бэлтгэж, нүхний дотор талыг элсээр дүүргэнэ.

Хөл бөмбөгийн талбайн урт 18м, өргөн 12м хэмжээтэй зүлэгжүүлсэн талбай байна. Хөл бөмбөгийн хаалга нь гадаа талбайд бат бөх тортой, 2, 5-3м урттай, 1, 5 м өндөртэй байна. Гар бөмбөгийн торны өндрийг хүүхдийн өргөсөн гарын хэмжээнд тохируулна. Сагсан бөмбөгийн талбайн хэмжээ 7х13м, сагсны шийд нь цагираг, тор, самбар, тулгуур хөл зэргээс бүрдэнэ. Шийдний цагиргийн диаметр 45см, самбарын урт 120см, өргөн 90см байна.Торыг газраас 180-200 см өндөрт байрлуулна. Сагсны шийдийг гадаа талбайд бат бөх төмөр, модоор хийж, сайтар бэхэлсэн байна.

Хавсралт 01

БАЯН-ОВОО СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ГАДНА ТОГЛООМЫН ТАЛБАЙД ШААРДЛАГАТАЙ
ТОГЛООМЫН ЖАГСААЛТ

№	Тоглоомын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ \сая.төг\	Нийт үнэ \сая.төг\	Жин, овор
1	Эргэдэг тоглоом	1 ком			
2	Гулгуурын иж бүрдэл	1 ком			
3	Гулгуурын иж бүрдэл	1 ком			
4	Дүүжин даажин	2 ком			
5	Элс усаар наадах тоглоом	2			
6	Сагсны шийд	2			
7	Сагс, Хөл бөмбөгийн талбай байгуулах хиймэл зүлэг	3 см 110 ш			
8	Хөл бөмбөгийн хаалга	2ш			
9	Хогийн сав	1 ком			
10	Савлуур	1 ком			
11	Сүүдрэвч	1 ком			
	Дүн				

Хавсралт 02

Эргэдэг тоглоом

Гулгуурын иж бүрдэл

4-5 насны тоглоом

2-3 насны тоглоом

Дүүжин даажин

Элс улсаар наадах тоглоом

Сүүдрэвч

Сүүдрэвч үнэ – 1.800.0000

Сагсны шийд

Хамгийн хямд үнэ
480000
"БУММ ХХК"
其他垃圾
Residual Waste
可回收物
厨余垃圾
Food Waste

Савлуур

Бага насны хүүхдүүд тоглох хөл бөмбөгийн мини хаалга. Хэмжээ: 125x79x63 см (L*W*H)

Савлуур

Хиймэл зүлэг

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН
ЭРХЛЭГЧ Э.ТУЛГАА